

МОНГОЛ БОЛОН СОЛОНГОСЫН БУДДЫН СҮМИЙН ХЭЭ ЧИМЭГЛЭЛИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Д.Наранцацрал

Дэд профессор, Доктор (Ph.D)

ШУТИС, БУХС, ХУС.

Д.Баярнэмэх

Мэргэжилтэн, Нийслэлийн Соёл,

Урлагийн газар

Энэхүү судалгаагаар Өрнө, Дорнын хээ чимэглэлийг харьцуулан судалж, гарал үүсэл, онцлог байдлуудыг тодорхойлов. Буддын шашны соёлд уламжлагдан ирсэн хээ чимэглэлийн дүрс, зохиомж, бэлгэдлийг нь судалж, Монгол Улс болон БНСУ-ын сүм хийдийн хээ чимэглэлийн ижил болон ялгаатай талыг харьцуулан судлахыг оролдсон. Бид энэхүү судалгааны ажилдаа БНСУ-ын Булгукса, Хаэинса, Трипитака, Тхондоса, Хваомса, Наксанса, Хэенгунса сүм хийдийг, Монгол Улсын Дашчойлин хийд, Гандантэгчинлэн хийд, Чойжин ламын сүм музей, Дамбадаржайлин хийдийг сонгон судалгааны объектоо болголоо.

Хээ угалз нь хүн төрөлхтний анхдагч дүрслэх урлагийн нэг төрөл, хийсвэрлэл, загварчлалын анхдагч мөн. Буддын сүм хийдийн хээ угалз нь өөр өөрийн байгаль цаг уур, зан заншлын хэв шинжийг тусгасан өвөрмөц тогтолцоо, зохиомж бүхий хээ угалзын иж бүрэн системтэй байдаг. Мөн аливаа нэгэн ард түмэн, үндэстний философи-логик сэтгэлгээний үр дүнд боловсорч, орчин тойрноо гоёж чимэх зориулалтаар хавсарга урлаг болсон нь өнө эртний судлалын ухаанаар шинэчлэгдэн батлагдсаар байна.

Монголд буддын шашин ихэд дэлгэрэхийн хамт Төвдийн архитектурын хийц маяг, хэлбэр, гоёл, чимэглэл Монголын архитектурт нөлөөгөө үзүүлжээ. Төвдийн уран барилгын хэв маягийн барилга нь тэгш дөрвөлжин хэлбэртэй нүүрэн тал нь энгийн боловч сүрлэг үзэсгэлэнтэй, ирмэгээр нь дугуй хэлбэрийн “толиор” чимэглэсэн байх нь түгээмэл юм. Монголд XVII зууны дунд үеэс төвд маягийн хоёр гурван давхар барилга бий болжээ.

БНСУ-ын сүм хийд, дуганы архитектур нь энгийн болон олон хэлбэрт дээвэртэй байдаг. Дээвэр нь налуу, дэрвийсэн хэлбэртэй бөгөөд байшингийн нүүрэн талын зураг чимэглэлийг хамгаалсан байдалтай байх аж. Нүүрэн талын дээврийг модон баганаар тулах ба тэдгээрийн тоо нь тэгш байдаг байна. Ийм барилга голдуу 1-4 давхар байхын хамт давхар бүхэн гоёмсог вааран асар дээвэртэй байв. Солонгосын архитектурын хэв маяг бүхний зохион байгуулалт

нь сүм дугануудыг том хэрмэн хашаан дотор бас дахин хамарлан барьсан хашаануудад байрлуулсан байх нь олонтаа.

Монгол болон Солонгосын буддын сүм хийдийн хээ чимэглэлээс доорх дөрвөн чимэглэлийг тодруулан судлая. Үүнд

- Бадамлянхуа цэцэг
- Луу
- Үлгэр домгийн амьтны баг

1. Бадамлянхуа - Ургамлын дүрс бүхий хээ

Бурхны шашны найман тахилын нэг бөгөөд ариун нандины бэлгэдэл болно. Бурхан бол орчлонгийн ариун нандины дээд тул түүнийг Бадамлянхуан дэлбээн дээр залруулан дүрсэлдэг. Энэтхэгт “бадам”, Төвдөд “мядаг”, Хятадад “лянхуа” гэх бөгөөд монголчууд “бадамлянхуа” гэж хэлж заншсан байна.

Лянхуа цэцэг нь буддын сүм хийдийн хамгийн түгээмэл бэлэг тэмдгүүдийн нэг юм. Мэдээж хэрэг цэцэгнүүдийг будда болон дарь эхүүдийн зурагнаас эхлээд хаалганы хүрээ, тааз, шүтээн, дээвэр хүртэлх хаанаас нь ч олж харж болно. /1-р зураг/ Буддизмын сургаалийг мэддэггүй хүн лянхуа цэцгийг энгийн нэг ургамал гэж боддог бол буддистууд эсрэгээрээ цэцгийг бурханлаг сүнслэг оршихуйн бэлгэ тэмдэг гэж үздэг.

Найман дэлбээт бадам цэцгийн ургамлын бүрхэвч дотор маш чухал нэгэн Буддын шашны сургааль буюу итгэл үнэмшлийн бэлгэ тэмдгийг агуулдаг. Энэ нь дөрвөн будда болон дөрвөн дарь эхүүд цолоороо жагсан байх ба дөрвөн будда нь дөрвөн сургаалийг төлөөлж, дөрвөн дарь эхүүд бүгдийг энэрэгч ачтан, буддын замналын арга барилын утгыг илэрхийлдэг.

Бадамлянхуа нь яагаад чухам найман дэлбээтэй байгааг тайлбарлавал: Хүний амин сүнс найман дэлбээтэй лянхуа хэлбэртэй байдаг. Тэрбээр буддагийн төрхийг олсоноор тэр хүмүүний зүрхэн дэх лянхуа дэлбээлэх нь оюун санааны бясалгалын үр дүн юм. Энэхүү найман дэлбээт лянхуаг олж харсанаар үйлийн үр болоод аливаа оюун ухааны урсгалаас ангид нэгэн хий оршихуйд шилждэг байна.

Монголд дэлгэрсэн ургамалын хээний томоохон бүлэгт Бадамлянхуа цэцэг ордог юм. Энэтхэг, Япон, Солонгос, Хятад зэрэг дорно зүгийн орнуудад лянхуа /Лотос/-цэцгийн язгуурт багтах гоёмсог өнгө, хэлбэр, бахдам сайхан үнэрт цэцгээс энэ хээний дүрс үүссэн байна. Мөн хажуунаас, дээрээс нь харсан байдлаар зурах тохиолдол байх ба дэлбээний хэлбэр олон янз, дэлбээ нь хэд хэд давхарлан үелсэн байдалтай дүрслэгдэнэ. Энэ үзэсгэлэнт цэцгийн ботаникийн

нэр нь *Nelbum Speciosum*, Азийн уугуул цэцэг. Милиндапанька сударт “Лянхуа бол булбарай зөөлөн, анхилуун тансаг үнэртэй, сэрүүн цэнгэг нуурын тунгалаг усанд ургадаг, зөгийг өөртөө урин дууддаг цэцэг” гэжээ.

Хүснэгт 1

Монгол бэлгэдэл	Солонгос бэлгэдэл
<p>Голдуу бумбагар, тал бүртээ дэлгэрч дэлбээлсэн цэцгийн хэлбэр нь товгор, бөмбөгөр зүйлд хээ тавихад ихэд тохирно. Бадамлянхуа хээний онцлог нь голоосоо дахин дахин дэлгэрсээр хэд хэдэн цэцэгтэй болгон дүрсэлсэн байдаг. Мөн хажуунаас, дээрээс нь харсан байдлаар зурагдах тохиолдол байх ба дэлбээний хэлбэр олон янз, дэлбээ нь хэд хэд давхарлан үелсэн байдалтай дүрсэлнэ. Бадам хээг эд юмст урлахдаа “намгийн лаг шаварт ургасан мөртлөө усны булингар хүрээгүй, бадамлянхуа мэт ариун сайхан байтугай” гэж бэлгэдэн ерөөсөн утгаар тайлбарлана.¹</p>	<p>Лянхуа нь замагтай булингартай тогтуун цөөрөмд хамгийн хурдан ургаж, цагаан ягаан усан цэнхэр өнгийн дэлбээнүүдээ усны мандалд дэлгэдэг. Иймээс лянхуа нь мунхаглал, шунал хүслийн энэ хорвоод амьдрал, ямагт тэр бүгдийн дээгүүр ариун тунгалаг, гоо үзэсгэлэнтэйгээр орших гэгээрсэн хүмүүний бэлгэдэл байсаар иржээ. Лянхуан навч дэлбээ нь хир тоос өөртөө үл халдах чадвартай нь шинжлэх ухаанаар тогтоогдсон бөгөөд Бурхан багш, Лянхуа цэцэгний навч дэлбээ нь өөртөө наалдсан хир тоосыг усан дуслаар өөрөө угааж цэвэрлэдэг зохилдолгоог, гэгээрсэн төрөлхтөний хорвоогийн дур хорхойсол, буртаг огтхон ч үл автан орших чадвартай харьцуулан олонтаа зүйрлэсэн байна.</p>



Монгол



Солонгос

/1-р зураг/

¹ Ц.Ядамжав “Хээ угалз”, УБ., 1995, 26-р тал.


2. Луу - Амьтныг дүрсэлсэн хээ угалз

Лууг хөх тэнгэр болоод хөрст газрын амьтан гэж Дорно дахинд үздэг ба дүрслэхдээ амаа ангайлган, хэлээ гарган хүрхэрч буй байдлаар дүрсэлдэг. /2, 3-р зураг/ Өрнөдийн луу хоёр хөлтэй байхад, Дорнын луу дөрвөн хөлтэй байдаг нь мэдээж сүм хийд чимэглэл дээр олонтаа харагддаг. Луу нь сүм хийдийн урд тулгуур, далавчтай шувуу, түүнчлэн тахилын ширээний, тааз, засал чимэглэл тулгуур дээрх халхавч, гадна шатны хажуу дээр чухал байр эзэлдэг юм.



Монгол

/2-р зураг/



Солонгос

/3-р зураг/

	Ялгаатай тал	Ижилхэн тал
Солонгос	Луугийн хүч төсөөлшгүй байх ёстой	Солонгосын луу нь Монголын уламжлалт хувилбартай төстэй. Толгой, буга шиг эвэр, могой гэдэс болон хайрс зэргээрээ төстэй.
Монгол	Дэлхийг бэлгэдэж баганынхаа ёзоороор уул, усан хээг, тэнгэрийг төлөөлж баганын их биеийг үүл, луугаар ороолгож хийснээрээ уг чимэг ертөнцийг бүхэлд нь багтаасан огүүлэмж аястай болж, дундарч барагдашгүй, бөхийж гудайшгүй чилгэр байх утгыг мөнхлөн урлаж өгснөөрөө сэтгэн урлахуйн гайхамшгийг илэрхийлдэг гэж хэлж болно.	

3. Үлгэр домгийн амьтны баг (*Monster mask*)

Биегүй мөчгүй дан нүүр нь Буддын танхимын гадаад дотоод чимэглэлийн нэг хэсэг болдог. Ихэвчлэн баганын дээд талд эсвэл таазны ирмэгээс, шүтээний чимэглэл дотор сийлсэн байдалтай, зураг хэлбэрээр байдаг. Ойртоод харвал товойсон хагас дугариг нүд, хамар том байх ба өргөн хамрын нүх харагдана. Нүүр нь үс, сахал, чихтэй байх ба хоёр нүдний дээд талаас хоёр том эвэртэй байна. Ам нь хоёр тал руугаа сунаан инээмсэглэсэн том хурц шүднүүд нь ил гарсан байдалтай байна. /4-р зураг/ Зарим нь луутай адилхан дүрстэй байх ба амнаас нь лянхуа дэлбээлж байгаа нь энэ луу биш гэдгийг баталж байна. Жинхэнэ төрх Kirttimukha² нь буддын сүм хийд болон Энэтхэгийн Шивагийн сүм хийдээс олдоно.



/4-р зураг/ Үлгэр домгийн амьтны баг (*Monster mask*)

Энэтхэгийн Шивагийн эсвэл Буддын сүм хийд нь хорссон сүнсийг үргээх хөөх олон баг байдаг ба эдгээрийн ихэнх нь гадаад төрхөөрөө Солонгосын сүмийн үлгэр домгийн амьтны багтай төстэй юм. Арслан царайт Kirttimukha баг нь санскрит хэлнээ Алдар нэрийн баг гэгддэг. Шивагийн уур хилэнг илэрхийлэн төсөөлсөн төдийгүй үнэнч шудрага байдлыг хамгаалагч гэгдэнэ. Арслан царайт баг ба

² Kirttimukha - Алдар нэрийн нүүр царай

Солонгос баг хоёрын гол ялгаа нь үлгэр домгийн амьтны аман дахь сувдан зүүлт юм.

Үлгэр домгийн амьтны аман дах Лянхуа цэцэг эсвэл дэлбээнүүд

Солонгосын сүмд байх үлгэр домгийн амьтны багны нэгнийх нь нэрийг hwi нүүр царай гэсэн Солонгос үг ба Hwi нь хятад ханзаараа олон өнгөтэй гэсэн утгатай юм. Солонгосын чимэглэл нь үндсэн хоёр хэсэгт хуваагдана.

1. Аманд нь юу ч байхгүй
2. Амандаа лянхуа цэцэг зуусан

Ихэнх багууд нь эхний хэсэгт орох бөгөөд үлдсэн хэсгүүд нь үлгэр домгийн амьтны багийн анхны төрх байдлын талаар мэдээлэл өгч байдаг.

Сүмийн хамгаалагчийн харц

Үлгэр домгийн амьтны баг нь уран зураг шиг сүмийг чимж байдаг. Солонгосын хамгийн шилдэг сийлсэн багууд Шагжамүни хаалга, Gaeamsa, Jeonduengsa, Jeongsusa зэрэг сүмүүдэд байдаг. Gaeamsa-д хоёулаа ямар ч эвэргүй хоёр модон баг байх ба зүүн талынх нь урагшаа харсан бол, баруун талынх нь хажуу тийшээгээ харсан байдаг. Jeonduengsa дахь баг нь урт модон дээр сийлсэн байх ба хурц нүд өргөн хамартай, хүнтэй төстэй харагддаг. Сүүлд нь Jeongsusa-гийн баг нь нүүр нь доошоо харсан байдалтай байдаг.

Үлгэр домгийн амьтны багийн нүд нь олон тийш харсан байдаг. Ганц толгойтой баг нь ихэвчлэн эгц урагшаа харсан байдаг бол хоёр болон түүнээс олон толгойтой багнуудын нүд нь өөр тийшээ харсан байдаг. Шагжамүни хаалганд байдаг олон багийг авч үзэхэд баруун хаалган дээрх нь доошоо харсан бол зүүн хаалган дээрх нь баруун тийшээ харсан байна. Hwaomsa-д байдаг Жанрайсиг хаалганы багуудыг авч үзэхэд зэрэгцээ гурван багийн голынх нь урагшаа харин зүүн, баруун талынх нь танхимын гол хэсэг рүү харсан байх жишээтэй.

Үлгэр домгийн амьтны баг нь сүмд муу муухай сүнсийг оруулахгүй, сүмийг цэвэр ариун байлгаж хамгаалах үүрэгтэй юм.

Монгол нутаг дэвсгэр дээрээс олдсон өөр нэгэн багийг авч үзье.



Улаан хэрмийн Шороон Бумбагар нь МЭ VI зууны сүүлч, VII зууны эхэн хагаст хамаарна хэмээн судлаач Л.Эрдэнэболд тогтоогоод байна. Нутгийнханы Шороон Бумбагар хэмээн нэрлэдэг тэрхүү дурсгалын гадаад байдал нь гэвэл, өндрөөрөө 4м, сууриараа 36м голч бүхүй шороон дов юм. Энэхүү шороон довд Монгол Казакстаны судлаачид археологийн малтлага судалгаа хийсний үндсэн дээр олон сонирхолтой дурсгалуудыг нээн илрүүлсэн юм. Түүний дотор үлгэр домгийн амьтны багийг ханын зурагт зурж үлдээсэн байв. /5-р зураг/

Энэ дурсгал нь одоогийн Монгол улсын нутаг буюу тухайн үеийн Түрэгийн хаант улсын Уйгурын үеийн язгууртны бунхант булш юм. Үхэр мэт толгойтой домгийн амьтны дүрслэл, бадам бололтой цэцгийн дүрслэл байгаа нь магадгүй бунханыг үлдээгчид бурхны шашныг ямар нэг хэмжээгээр мэддэг, шүтдэг байсны баримт байж болно.

Энэ бүхнээс харахад улс орон бүрт буддын шашин нь ястан, угсаатан, үндэстнүүдийн сургаал, номлолын ном судар, сүм хийдийн дуганы архитектур, урлал, чимэглэл хөгжлийн гайхамшигт түвшинд хүрч хүн төрөлхтний соёлын үнэлж баршгүй үнэт өв болон үе дамжин хадгалагдаж, хамгаалагдсаар байгаа билээ. Монголын бурханы шашин сүм хийд, дуганы бүтэц урлал, чимэглэлийн талаар хэдэн зууны турш боловсруулан хэрэглэж байсан оюуны баялаг өв уламжлалд холбогдох цэгцтэй мэдээллийн сан бараг байхгүй, тэр их мэдлэг, арга ухааныг эзэмшсэн ахмадууд өдрийн од мэт ховордож байгаа үед бид эл асуудлыг хөндөн судлах нь зүй ёсны хэрэг юм.

Дүгнэлт

Дээрх харьцуулсан судалгааг нэгтгэн дүгнэвэл:

1. Буддын сүм хийдийн хээ чимэглэл Монголд нэвтэрч орж ирсэнээр өөрийн агуулга, хэлбэр, дүр дүрслэлээ хамтад нь баяжуулан, хөгжүүлж ирсэн төдийгүй БНСУ-ын буддын хээ чимэглэлтэй адил гүнзгий санаа, гүн ухааны аясаар нэн баялаг шинжтэй байгаа юм.
2. Буддын хээ чимэглэл нь ард түмнээр дамжуулан нийгэмд үнэт чанар тэр тусмаа оюун санааны үнэлэмжүүдийг гаргаж өгдөг төдийгүй ард түмний оюуны амьдралын баримт нь болдог. Тухайн үеийн шашин, төр хосолсон нийгэмд сүм хийдийн хээ чимэглэлийн ухаан буддын соёлын хувьд чухал байр суурь эзлэж байжээ.
3. Буддын сүм хийдийн хээ чимэглэл хадгалах, дэлгэрүүлэх, хэрэглэх, судлах субъектийн үйл ажиллагаа уран сайхны соёлд оролцох чухал бүрдүүлэгч хэсэг юм. Тийм ч учраас буддын сүм хийдийн хээ чимэглэл түүний ач холбогдолыг ойлгуулахад сүм хийдийн болон сүсэгтэн олны мэдлэгийн ойлголтын түвшинг дээшлүүлэх шаардлагатай хэмээн үзэв.
4. Буддын сүм хийдийн хээ чимэглэл итгэл үнэмшил, домог бишрэлийн нэгэн төрөл болон уламжлагдаж, залбирал мөргөлийн нэгэн эх булаг ёсон болохыг бидний харьцуулсан судалгааны үр дүн харуулав.
5. Буддын сүм хийдийн хээ чимэглэл нь олон түмний сэтгэл санааг эзэмдэх нөлөө бүхий хүчин болон хувирч улмаар бие хүний шашны ухамсар бүрэлдэн тогтоход чухал нөлөө үзүүлэхэд хүргэсэн. Түүнчлэн Монгол орны эрс тэс уур амьсгалыг зөөлрүүлэх гэж Буддын сүм хийд чимэглэлдээ дулаан өнгө нэмсэнээр хүний сэтгэлийг дулаацуулах зорилготой байсан хэмээн үзлээ.

Буддын сүм хийдийн хээ чимэглэлийг уран сайхны соёлын хэмжээнд судлан боловсруулах нь танин мэдэхүйн төдийгүй уламжлалт соёлоо нягтлан судлах судалгааны ач холбогдолтой юм. Энэ утгаараа орчин үеийн хүмүүнлэгийн ухааны хөгжлийн түвшнээс цаашид нарийвчлан судалснаар дорнын ард түмний сэтгэлгээний өв соёлыг боловсруулахад чухал түлхэц болж өгнө хэмээн үзэж байна.

Ашигласан бүтээл

Монгол хэлээр

1. Б.Адьяа, Ж.Батсуурь, Г.Пүрэвбат, Н.Уртнасан, Д.Хишиг, С.Шархүү, “Бурханы шашны сүм дуганы урлал,чимэглэлийг сэргээн амилуулах монгол уламжлалт арга ухааны гарын авалга” Улаанбаатар, 2006
2. Л.Батчулуун, “Монгол дархны урлаг I боть”, Улаанбаатар, 2009
3. Б.Болд, “Монгол ардын хээ угалз”, Улаанбаатар, 2007
4. “Монголын соёлын түүх ”, Улаанбаатар, 1999
5. Д.Наранцацрал, “Гоо зүйн үндэс”, Улаанбаатар, 2013
6. Х.Нямбуу,“Халхын зарим нутгийн хээ угалзын зүйл”, Улаанбаатар, 1968
7. Ж.Өлзий ,“Монголын дурсгалт барилгын түүхээс”, Улаанбаатар, 1992
8. Д.Энхдаваа, “Монгол хээ чимэг”, Улаанбаатар, 2000
9. Ц.Ядамжав, “Монгол ардын хээ угалзын эх дүрсүүд”, Улаанбаатар, 1985
10. Ц.Ядамжав, “Хээ угалз”, Улаанбаатар, 1995
11. Д.Манибадар, ”Монгол үндэсний хээ угалз”, Улаанбаатар, 2012
12. Д.Майдар, “Монголын архитектур ба хот байгуулалт”, Улаанбаатар, 1972

Гадаад хэлээр

1. Алтайский орнамент, “Горно-алтайск”, 1971
2. Д.Майдар, “Архитектура и градостроительство Монголии” М.1971, приложение №1
3. Н.Чүлтэм, “Архитектура Монголии”, 1988
4. Н.М.Шепетильников, ‘«Архитектура Монголии ”, М. 1960
5. Neo Gyun, “Korean Temple Motifs”, Korean., 2005